

“LG-тэй хамт явуулах Олон соёлын сургууль”-д

9 дахь удаа(2026-2027 он)-гийн сурагч элсүүлэх тухай зарлал

“LG-тэй хамтран явуулах Олон соёлын сургууль” нь олон соёлт гэр бүлийн өсвөр насны хүүхдүүдэд зориулж системтэй, мэргэжилийн боловсролыг үнэ төлбөргүй олгох хөтөлбөр юм. Уг сургуулийн цахим ба танхимын хос хэл, соёлын сургалт болон дэлхийн иргэний боловсролоор дамжуулан өндөр өөрийн үнэлэмжтэй, өөртөө итгэлтэй хүн болж өсөх боломжтой болно. Ирээдүйн глобал авьяастнаар өсөх сурагчдыг элсүүлж байна.

■ Элсэлтийн тухай мэдээлэл

1. Тавигдах шаардлага

- ① БНСУ-ын иргэншилтэй олон соёлт гэр бүлийн хүүхэд байх (2026 оны 3-р сарын байдлаар бага сургуулийн 1-р анги - Дунд сургуулийн 3-р анги)
 - Эцэг, эхийн нэг нь гадаад улсын иргэншилтэй эсвэл БНСУ-ын иргэншил авсан сурагч
 - Гадаад улсад төрөөд амьдарч байгаад БНСУ-д амьдрахаар ирсэн сурагч
- ② Манай сургуулийн 2 жилийн сургалтыг тууштай оролцохыг хүсэж байгаа сурагч

2. Элсэлтийн хөтөлбөр болон сургалтын төрөл

- ① Элсэлтийн хөтөлбөр: Бага ангийн хөтөлбөр, Дунд ангийн хөтөлбөр
 - Бага ангийн хөтөлбөр: Бага сургуулийн 1-6-р ангийн сурагч (2026 оны 3-р сарын байдлаар)
 - ※ Бага сургуулийн 6-р ангийн сурагч(2026 оны байдлаар)-ийн хувьд, бага ангийн хөтөлбөрт хүсэлт гаргасан байх шаардлагатай бөгөөд хоёр жилийн дараа (2027 онд) дунд сургуульд орох болсон ч гадаадын дадлагын хөтөлбөрт оролцох боломжгүй. Харин дунд сургуульд орсоны дараа “Дунд сургуулийн сурагчид зориулсан Кэмп”-д оролцох боломжтой.
 - Дунд ангийн төрөлбөр: Дунд сургуулийн 1-3-р ангийн сурагч (2026 оны 3-р сарын байдлаар)
- ② Сургалтын төрөл: Хятад хэл, Япон хэл, Орос хэл, Монгол хэл, Вьетнам хэл, Индонез хэл, Тайланд хэл, Солонгос хэл* (Нийт 8 хэл)
 - ※ Солонгос хэлний хувьд гадаад улсад төрөөд БНСУ-д амьдрахаар ирсэн сурагч учраас эх хэлний сургалт биш, “Гадаад хүнд зориулсан Солонгос хэл”-ний сургалтад хамрагдах хэрэгтэй тохиолдолд сонгож болно.

■ Бүртгэлийн үе шат

1. Бүртгэл явагдах хугацаа

Цагийн хуваарь	Бага ангийн хөтөрбөр	Дунд ангийн хөтөлбөр
1-р үе шат: Баримт бичиг хүлээн авах 2025.11.17.(Да)-12.21.(Ня)	Манай сургуулийн цахим хуудсанд орж бүртгэнэ үү.	
Тэнцсэн сурагчдыг зарлах 2025.12.29.(Да)	(Хамаарахгүй)	Манай сургуулийн цахим хуудсанд зарлах бөгөөд мессежээр мэдэгдэнэ.
2-р үе шат: Ярилцлага 2026.01.24.(Бя)~01.25.(Ня)	(Хамаарахгүй)	Сонгон шалгаруулах кэмпт оролцож ярилцлага өгнө (1 хоног 2 өдөр)
Тэнцсэн сурагчдыг зарлах 2026.01.27.(Мя)	Манай сургуулийн цахим хуудсанд зарлана	

* Сонгон шалгаруулах кэмп 1 хоног 2 өдрөөр үнэ төлбөргүй явагдана (унааны зардал багтахгүй)

* Дээрх хуваарь нь манай сургуулийн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болно.

2. Сонгон шалгаруулалтын шалгуур

① Бичиг баримтын бүрэн байдал: Хүсэлт, өөрийн танилцуулга зэрэг бичиг баримтуудыг бүрэн хагасан байдал болон агуулгыг нэгтгэж үнэлнэ.

② Орлогын түвшин: Өрхийн орлогын түвшингээр үе шаттай оноо олгоно.

※ Үндсэн амьжиргааны халамжийн хүртэгч эсвэл бага орлоготой өрхийн тодорхойлолт(차상위계층)(Өрх толгойлсон эх/эцэгтэй гэр бүлийн тодорхойлолт, Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийн тодорхойлолт) байвал хавсгарлаж болно.

③ Давуу эрх олгох: “Сонгосон хэлтэй холбоотой” шалгалтын дүнгийн хуудас, шагнал гэх мэт

Жишээ: LG олон соёлт сургуулийн хос хэлний түвшин тогтоох шалгалт, HSK, JLPT зэргийн шалгалтын дүнгийн хуудас, Хос хэлний ярианы тэмцээнээс авсан шагнал гэх мэт

※ Дүнгийн хуудас болон шагналын хүчинтэй байх хугацаа: Уг зарлал зарласан өдрөөс 2 жилийн дотор, сонгосон хэлтэй холбоотой байх ёстой

■ Сургалтын хугацаа болон агуулга

1. Сургалтын хугацаа: 2026 оны 3-р сар - 2027 оны 12-р сар

- 2 жилийн хугацаа (4 улирал)-гаар явуулна.

2. Сургалтын агуулга

Ангилал	Бага ангийн хөтөлбөр	Дунд ангийн хөтөрбөр
Онлайн	① 1:1 хувийн онлайн хичээл - Тухайн хэлний мэргэжилтэй Хангүг Гадаад Судлалын Их Сургуулийн оюутан(бакалвар, магистр) эсвэл уг сургуулийн төгсөгч хичээл заана - 16 долоо хоног(1 жил, 2 улиралын систем / 3-6-р сар, 9-12-р сар) - Нэг долоо хоногт нэг удаа, 45 минут	
	② Дэлхийн иргэний боловсрол - Нийтэч үзэлтэй хүн болгон өсгөж, арьс өнгө, соёл, шашныг үл хамааран, дэлхийн асуудалд анхаарал хандуулж, тэдгээрийг шийдвэрлэх мэдлэг, үнэ цэнэ, хандлагыг хөгжүүлэх боловсрол	
Оффлайн	① Амралтын кэмп (1 хоног 2 өдөр/жилд нэг удаа) - Хэл, соёлын гүнзгийрүүлсэн сургалт - Янз бүрийн туршлагын хөтөлбөр	① Тусгай кэмп (1 хоног 2 өдөр/жилд нэг удаа) - Хэл, соёлын гүнзгийрүүлсэн сургалт
		② Гадаад/Дотоодын дадлага - Гадаад дахь Их сургуульд суралцах, гадаад соёлтой танилцах, өөрөө төсөл хэрэгжүүлэх - Гадаадад очиж суралцах боломжгүй тохиолдолд дотоодод төсөл хэрэгжүүлэх

※ Сургалттай холбоотой дэлгэрэнгүй мэдээллийг хавсралтаас харна уу.

■ Бүртгүүлэх арга ба бүрдүүлэх бичиг баримт

1. Онлайнаар бүртгүүлэх арга

- ① Манай сургуулийн цахим хуудсанд орж гишүүн болоод онлайнаар бүртгэл хийнэ.
 - Хайх арга: Naver цахим хуудасны хайлтын цонхонд → 'LG다문화학교'-г бичиж хайх
 - Цахим хуудасны хаяг: <https://lgglobalschool.co.kr>
- ② Зөвхөн **цахим бүртгэх систэмд** орж бүртгэх боломжтой.
(Шуудан, факс, И-мэйлээр бүртгэх боломжгүй)

2. Бүрдүүлэх бичиг баримт

Бичиг баримтын нэр	Заавал эсэх
① Хүсэлт болон өөрийн танилцуулга	○
② Эцэг эх хоёрын эрүүд мэндийн даатгалын тодорхойлолт(건강보험 자격득실 확인서) болон төлбөрөө төлсөний хутай тодорхойлолт(건강보험 납부 확인서)*	○
③ Оршин суугчийн бүртгэлийн лавлагаа(주민등록등본)*	○
④ Бусад бичиг баримт (хамрагдах тохиолдолд)-ыг файл болгож хавсгарлах ※ Үндсэн амьжиргааны халамжийн хүртэгч(기초생활수급자)(амьжиргаа, байр, эмчилгээ, боловсрол) болон бага орлоготой өрхийн тухай тодорхойлолт(차상위 계층), Хөгжлийн бэрхшээлтэй хүний тодорхойлолт, Өрх толгойлсон эх/эцэгтэй гэр бүлийн тодорхойлолт гэх мэт	хамрагдах тохиолдолд
⑤ Хэлний шалгалтын дүнгийн хуудас, хэлтэй холбоотой шагналын өргөмжлөл ※ LG олон соёлт сургуулийн хос хэлний түвшин тогтоох шалгалт, HSK, JLPT зэргийн дүнгийн хуудас, хэлтэй холбоотой авсан шагналын өргөмжлөл	хамрагдах тохиолдолд

* ②, ③-ыг татаж авах аргыг хавсарсан тайлбар(PDF)-аас харна уу.

■ Зөвлөгөө авах ба Лавлах

1. Хариуцагч байгуулага: Хангүг Гадаад Судлалын Их Сургуулийн харъяа Олон соёлт боловсролын төв (Сөүл хот, Төв байшингийн 603 тоот)

① Холбоо барих утас

- Утас : 02)2173-2586, 2577, 2551, 2588, 2576

- Факс : 02)2173-3383

② Ажлын цаг : Өглөө 9 цаг - орой 5 цаг (Цайны цаг: өдөр 12 - 1 цаг)

2. Зөвлөгөө авах (Утас, биеэр очих эсвэл дараах шугамаар зөвлөгөө авах боломжтой)

① Instagram : @lg_global_school

② Цахим хуудас : <https://lgglobalschool.co.kr/ko>

③ И-мэйл : hufslanglg@hufs.ac.kr

※ Манай сургуулийн дэлгэрэнгүй мэдээллийг SNS-ээс харна уу.

(Youtube/Facebook ‘LG 다문화학교’)